

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-9</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>10-18</i>

---

1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	10-18
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 22-ны  
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 16 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Э.Бат-Амгалан, Ч.Ундрэм.

**Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг” гэснийг “бүсийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 2  
Бүгд: 7  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “4.1.7-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчлөн, мөн зүйлийн 6.1.6 дахь заалтын “их өгөгдөл” гэсний дараа “блокчэйн” гэж нэмэх, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болгон өөрчлөх:

“6.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 2  
Бүгд: 7  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтын “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “төрөөс” гэснийг, 7.3 дахь хэсгийн “батлахад” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 2  
Бүгд: 8  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “дараах” гэсний өмнө “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 3

Бүгд: 8  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 9.1.1 дэх заалтын “гарааны компанийг бойжуулах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 3  
Бүгд: 8  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хувийн өмчит хуулийн” гэснийг “бусад” гэж, 10.2.2 дахь заалтын “8.1.5-д” гэснийг “8.1.4-т” гэж, 10.2.3 дахь заалтын “8.1.6” гэснийг “8.1.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “орон тооны бус зөвлөл” гэснийг “Үндэсний зөвлөл” гэж өөрчилж, мөн заалтын “чиг үүрэг бүхий” гэснийг хасаж, мөн зүйлийн 11.5.3 дахь заалтын “ажлын” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.8-д заасан” гэж нэмж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл /Цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.” гэсний дараа “Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг “Зөвлөл”-ийг “Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “эхлэлтийн” гэсний өмнө “хуулийн этгээдийн” гэж нэмж, мөн зүйлийн 12.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Б.Саранчимэг нар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.8 дахь заалтын “бизнест” гэснийг “компанид” гэж өөрчлөн, мөн зүйлийн “13.3.8” гэснийг “13.3.7” гэж, “13.3.9” гэснийг “13.3.8” гэж, “13.3.10” гэснийг “13.3.9” гэж, “13.3.11” гэснийг “13.3.10” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.4.Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан, Төслийн 13.3.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын “5.3.10” гэснийг “5.3.18” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Нэг.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “5.2<sup>1</sup>” гэснийг “5.15” гэж өөрчлөх, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “15.1.18” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “болон” гэснийг “бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.



Тав.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 42 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 58 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,  
11 цаг 16 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Э.Батиугар:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Учрал сайд 28 дугаар тойрог, Батиугар 28 дугаар тойрог, Ганхуяг гишүүн 26 дугаар тойрог, Идэрбат гишүүн 18 дугаар тойрог, Саранчимэг гишүүн 22 дугаар тойрог, Сэргэлэн гишүүн 7 дугаар тойрог, Чинбүрэн гишүүн 23 дугаар тойрог. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдөр хэлэлцэх асуудал 1 асуудал байгаа.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүд.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудал руугаа оръё.

Ажлын хэсэг танилцуулъя. Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхээгийн Тэнгис Цахим

хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Малтарын Солонгоо Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Цахим хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч. Ажлын хэсэг танилцуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэсэн заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Өнөөдөр шинэ энэ төхөөрөмж ашиглаж байна. Тэгэхээр эхлээд хамгийн эхлээд цөмөөрөө нэг туршилтын санал хураалт явуулж үзэх үү, үүгээр. Туршилт, туршилтын санал хураалт явуулж үзье. Санал хураалт.

Ахиад нэг туршилтын санал хураалт явуулаад үзчихье. Анхных болохоор жоохон яалаа, бас. Санал хураалт явуулъя.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан саналтай гишүүд алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Чинбүрэн гишүүн. Байхгүй байна.  
Чинбүрэн гишүүний микрофон.

**Ж.Чинбүрэн:** Одоо ажиллаж байна. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “албан ёсны хаяг, байришил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг” гэснийг “бүсийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.5 дахь заалтыг хасах саналтай байна.

Бид бас энэ нөгөө бүсийн хөгжилтэй холбоотой бүсжүүлж, энэ хуулийнхаа төслийг явуулъя.

**Э.Батиугар:** Эхлээд ахиад нэг туршилтын санал хураалт явуулаад үзчихье. Туршилтын санал хураалт. Туршилтын санал хураалт явж дууслаа.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан Чинбүрэн гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 71,4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйл холбогдуулан асуулт асуух, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байна. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Энэ дээр бас өөрчлөлт оруулмаар байна. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “4.1.7-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчлөн, мөн зүйлийн 6.1.6 дахь заалтын “их өгөгдөл” гэсний дараа “блокчэйн” гэж нэмэх, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болгон өөрчлөх:

“6.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон дүрэм,

журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;” гэсэн өөрчлөлт оруулъя.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 71,4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Уучлаарай. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Дарга, энэ төслийн Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтын “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “төрөөс” гэснийг, 7.3 дахь хэсгийн “батлахад” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмж оруулах саналтай байна. Үүнийг дэмжиж өгнө үү.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний гаргасан саналаар санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух саналтай гишүүд байна уу? Чинбүрэн гишүүн микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Энэ төслийн 8 дугаар зүйл дээр ийм санал байна. Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “дараах” гэсний өмнө “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмж, мөн зүйлийн

8.1.1, 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;**

**8.1.2.мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллах;” гэсэн ийм саналуудыг оруулж байна.**

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний гаргасан саналаа санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 62,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Чинбүрэн гишүүн саналтай юм байна.

**Ж.Чинбүрэн:** Би энэ Харилцаа холбооны яамныхантай бас нөгөө хууль давхцал хийдэлтэй бас ажиллаж байсан. Эд нар маань их сайн ажилладаг залуус байгаа. Тийм. Гэхдээ бас нэг энэ юуны сайн нэр томьёо энэ тэрээ сайхан бас хуульд нийцүүлж янзлахгүй бол болохгүй байгаа зүйл байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 9.1.1 дэх заалтын “гарааны компанийг бойжуулах,” гэснийг хасчихъя. 9.1.1 дэх заалтыг. 9.1.1 дэх хэсгийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаад, мөн зүйлийн 9.1.1 дэх заалтын “гарааны компанийг бойжуулах,” гэснийг хасчихъя.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Чинбүрэн гишүүний гаргасан санал 62,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Надад 1 санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хувийн өмчит хуулийн” гэснийг “бусад” гэж, 10.2.2 дахь заалтын “8.1.5-д” гэснийг “8.1.4-т” гэж, 10.2.3 дахь заалтын “8.1.6” гэснийг “8.1.5” гэж тус тус өөрчлөх.

Сая миний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Надад 1 санал байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “орон тооны бус зөвлөл” гэснийг “Үндэсний зөвлөл” гэж өөрчилж, мөн заалтын “чиг үүрэг бүхий” гэснийг хасаж, мөн зүйлийн 11.5.3 дахь заалтын “ажлын” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.8-д заасан” гэж нэмж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.”

Санал хураалт явуулъя.

Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Хууль санаачлагч Учрал сайдаас асууна. Би Батиугар даргын хэлж байгаа Үндэсний зөвлөл гэдгийг дэмжиж байна. Ерөөсөө энэ Үндэсний зөвлөл байх ёстой. Хүч повер хүчтэй байх ёстой.

Тэгээд сая бас ямар улсууд байх вэ гэдгийг нь бас тодорхойлоод өгч байх шиг байна. Ямар хугацаагаар, хугацаа гэж байна уу, тийм ээ. Тийм хугацаатай байхгүй бол тэр томилогддог хугацаатай, яаж шалгаруулах юм. Яг нөгөө хүний эмийн зөвлөлтэй адилхан байхгүй юу. Сая эмийн түр хороо би ажиллууллаа. Хүний эмийн зөвлөл дээр гарч байгаа алдаа нь нэг сайд гарч ирээд л нэг журам гаргачихдаг.

Тэгээд тэнд хэн хэнийг оруулах вэ гээд өөрийнхөө командыг оруулчихдаг. Тэгээд л юу дуртай юмаа батлаад сууж байдаг. Тэгэхээр аль болохоор энэ нөгөө ил тод байх, ажиллах журам нь тодорхой байх. Сая би Батиугар даргын хэлж байгаа саналыг дэмжиж байна. Харин хугацааны асуудал байна уу. Ямар хугацаатай сонгож байх юм.

**Э.Батиугар:** Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Энэ хууль дээр нэг шинэ тийм орон тоо бий болгохгүй. Яг энэ Үндэсний зөвлөл гэж яриад байгаа одоо энэ зарчмын зөрөөтэй санал хураалгаж байгаа зөвлөл өөрөө ийм орон тооны бус зөвлөл. Тэгэхдээ үүний ажлын алба нь одоогийн төрийн өмчит үйлдвэрийн газар болох энэ мэдээлэл технологийн үндэсний парк шууд ажлын алба нь болно гэж байгаа.

Тэгээд тэр зөвлөл юу шийдэх вэ гэхээр энэ дүрэм журмуудаасаа гадна нөгөө онлайнаар виртуал бүсэд үйл

ажиллагаа явуулах компаниуд хүсэлтээ явуулаад тэдгээрээс нь эдгээр компаниудын шаардлагуудыг хангалаа гэдгийг нь хүлээж аваад тэгээд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.

Тэгэхээр хугацаагүйгээр байгуулагдаж байгаа. Гэхдээ сая хувийн хэвшлийнхэнтэй уулзалт хийсэн юм.

Тэгээд тэр үеэр хууль дээр энэ зөвлөлийнхөө бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувийг нь ер нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн төлөөллийг оруулчхаач ээ гэсэн. Тэгэхээр нь энэ Батиугар гишүүний саналыг би бас дэмжиж байна. Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувийг нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлье гээд явчихвал бас янз бүрийн тийм ээ, төрийн албан хаагчдын оролцоо нь багасчихна гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, Зөвлөлийг тодорхой хугацаатайгаар байгуулж болно гэдэг байж болно. Тэгэхээр Чинбүрэн гишүүн хэрвээ ийм саналтай байвал бас та санал гаргаад явуулбал боломжтой шүү гэж. Тийм.

**Э.Батиугар:** Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг нээе.

**Б.Батцэцэг:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 11.7 дээр Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газраас тогтооно гэсэн зохицуулалт байгаа. Тэгэхээр Засгийн газрын тогтоолоор хугацаатай, хугацаагүй эсэхийг бас шийдээд явах боломжтой гэж харж байгаа.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Яг энэ дээр чинь л асуудал үүсдэг байхгүй юу. Нөгөө дүрэм



журам, эрхтэн дархтанд үлдээхээр л асуудал үүсчихнэ.

Тийм учраас эхнээсээ тодорхой байя, хугацаа тавиад өгчихье. Жишээлбэл би өөрөө их сайн мэдэж байгаа байхгүй юу. Энэ чинь нөгөө аягүй тийм чухал шийдвэр гаргах зөвлөл байхгүй юу. Хэдий энэ орон тоо, орон тооны бус ч гэлээ гэсэн, тийм ээ, энэ чинь чухал чухал шийдвэрүүд гаргана. Тэр нөгөө татварын болон юуны орчны дэмжлэгүүдийг та виртуал орчинд ажиллаж байгаа мөн гэдгийг хэлээд өгөх байхгүй юу. Тийм учраас хэдүүлээ хугацаа тавьчихъя. Жишээлбэл хүний эмийн зөвлөлд бид 3 жилээр гээд өгч байсан. Тэгээд 1 сонгон шалгаруулдаг маягаар. Тийм ээ.

Тэгэхээр 1 сайд ирээд л хугацааг нь өөрөө солиод байхгүйгээр ерөөсөө тогтмол үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн үндэсний зөвлөл байх тал дээр хугацаа тавьж өгөх нь өөрөө чухал гэсэн ийм саналтай байна. Тэгэхээр би бас энэ дээр хугацаа тавья гэсэн тэрийгээ 2 байх уу, 3 байх уу? Харин үүнийг тийм, энэ талаараа хэдүүлээ харин ярилцаж болж байна.

**Э.Батиугар:** Ганхуяг гишүүн асуулттай байна. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

**Х.Ганхуяг:** Би яах вэ, нөгөө зөвлөл дээр яамны үйл ажиллагааг яаж байгаа юм биш шүү, би яах вэ зүгээр Үндэсний зөвлөл гэж байвал магадгүй зүгээр Ерөнхий сайдаар ахлуулаад, ажлын алба нь болон юу нь болохоор яам байвал арай ач холбогдолтой шүү. Яагаад гэхээр энэ чинь зөвхөн яамны асуудал зөвхөн салбарын асуудал биш бусад салбаруудаар дэмжүүлэх асуудал орж ирнэ шүү дээ. Татварын асуудал орж ирнэ. Сангийн яамны төлөөлөл байхгүйгээр энэ та нар салбар дээр юм яриад ямар ч дэмжлэг авч чадахгүй. Тэр нөгөө Ерөнхий сайд ойлголттой байж байж, тэгээд ажлын харин, та нар

ажлын албыг нь хийнэ ээ гэх юм бол дэмжигдэх асуудлууд чинь арай илүү бодитой болно шүү дээ.

Тэгэхээр энэ дээр сайд аа, та дэмжиж байвал харин зарчмын зөрөөтэй санал гараад Үндэсний зөвлөлөө Ерөнхий сайдын дэргэд байгуулаад ажлын алба нь Мэдээлэл технологийн яам байна гээд яачихвал илүү бодитой байх байх. Салбарын дэмжлэг нь ч илүү байх байх.

**Э.Батиугар:** Одоо түрүүн миний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Надад 1 санал байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “эхлэлтийн” гэсний өмнө “хуулийн этгээдийн” гэж нэмж, мөн зүйлийн 12.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт”. Саяын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Надад 1 санал байна.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.8 дахь заалтын “бизнес” гэснийг “компанид” гэж өөрчлөн, мөн зүйлийн “13.3.8” гэснийг “13.3.7” гэж, “13.3.9” гэснийг “13.3.8” гэж, “13.3.10” гэснийг “13.3.9” гэж, “13.3.11” гэснийг

“13.3.10” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.4.Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.” гэж. Санал хураалт явуулъя, сая гарсан саналаар.

66,7 хувиар дэмжигдлээ. Саяын санал.

Саранчимэг гишүүний микрофоныг нээе.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Энэ төслийн 13.3.11-ийг бүхэлд нь энэ заалтыг хасах саналтай байна. Тэгэхээр энэ яг нөгөө виртуал орчинд ажиллаж байгаа үед нөгөө түрээс байхгүй учраас үүнийг хасах саналтай байна. Тийм.

**Э.Батиугар:** Саранчимэг гишүүний гаргасан саналаас санал хураалт явуулъя. Санал хураалт.

Саяын санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

1 зарчмын зөрөөтэй санал байна.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын “5.3.10” гэснийг “5.3.18” гэж өөрчлөх. Саяын гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

55,6 хувиар саяын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Түрүүн Чинбүрэн гишүүн зарчмын зөрөөтэй санал бичгээр гаргасан. Тэгээд 11 дүгээр зүйлтэй холбогдуулан

Чинбүрэн гишүүн бичгээр гаргасан саналын томъёолол байгаа.

Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл /Цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.” гэсний дараа “Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна” гэж нэмэх. Санал хураалгаж өгнө үү.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан санал хураалт явуулъя. Сая Чинбүрэн гишүүний гаргасан саналаар.

Чинбүрэн гишүүний гаргасан санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Мөн сая 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Ганхуяг гишүүн бичгээр санал ирүүлсэн байна. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

**Х.Ганхуяг:** Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг “Зөвлөл”-ийг “Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.” гэж санал оруулах гэсэн юм. Баярлалаа.

**Э.Батиугар:** Баярлалаа. Сая Ганхуяг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ганхуяг гишүүний санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Сая нөгөө нэг дэмжсэнтэй холбогдуулан заалт хасагдсан. Тэгээд үүнтэй холбогдуулаад дэс дараалал өөрчлөгдсөн тул ахиад 1 санал хураалт явуулъя.

Тэгээд Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс



дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал хураалт явуулъя.

66,7 хувиар дэмжигдлээ.

Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн,

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Байгаа юм уу.

3 дугаар зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

Энэ хуулийн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж. Саяын гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

55,6 хувиар дэмжигдлээ, саяын санал.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн,

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцье.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? 1 санал байна.

Энэ Төслийн 1 дүгээр зүйлийн “5.2<sup>1</sup>” гэснийг “5.15” гэж өөрчлөх. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж.

Саяын гаргасан саналаас санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн,

Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй, алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? 3 дугаар зүйлтэй холбогдуулан 1 санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт явуулъя.

Саяын гаргасан саналаар санал хураалт. Энэ дандаа хугацааны юу яваад байгаа юм байна шүү дээ, тийм ээ.

Саяын гаргасан санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой энэ асуулт асуух гишүүд байна уу? Энд 1 санал, ахиад хугацааны асуудал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “15.1.18” гэж өөрчлөх. Санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Энэ дээр ахиад 1 санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “болон” гэснийг “бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ” гэж өөрчлөх. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

Саяын санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүд байна уу?

1 санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон

өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

Саяын санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн,

Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

1 санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт явуулъя.

Саранчимэг гишүүний микрофоныг нээе.

**Б.Саранчимэг:** Энэ санал дээр дэмжсэн санал өгсөн боловч болсонгүй. Энэ саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулна уу.

**Э.Батиугар:** Саранчимэг гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Тэгэхээр өмнөх санал хураалтаа ахиж явуулъя. Санал хураалт.

Туришлын шинэ тоног төхөөрөмж өнөөдөр анх удаа ашиглаж байгаа юм. Үүнтэй холбогдуулан бас техникийн асуудал гарч байна л даа. Тэгэхээр саяын саналыг энэ яагаад байна, гацаад байх шиг байна, тийм ээ, бүр байхгүй.

**Б.Саранчимэг:** Энэ нөгөө татгалзсан дээр ч алга, дэмжсэн дээр ч алга. Тэгэхээр энэ саналыг бас дахиж хүчингүй болгож, дахин санал хураалт явуулна уу.

**Э.Батиугар:** Саранчимэг гишүүний саналаар санал хураалт явуулъя. Энэ шинэ технологитой холбогдуулан бас тодорхой хэмжээний бас алдаа гараад байна.

Тэгэхээр санал хураалт ахиад явуулъя.

Горимын санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Тэгэхээр түрүүчийн санал хураалтаа ахиж явуулъя. Санал хураалт.

Санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа гэж хэлье.

Мөн ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ